



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 9 дүгээр  
сарын 13-ны өдөр


Дугаар 250

Улаанбаатар  
хот

## Зураг төсвийн ажил гүйцэтгүүлэх тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 10.1.14, 29.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө болон Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээр ирэх жилүүдийн төсвийн төсөлд тусган хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд шаардлагатай зураг төсвийн ажлын тоог хавсралт ёсоор баталсугай.
2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан зураг төсвийг гүйцэтгэх компанийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, шалгарсан этгээдтэй 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн дотор гэрээ байгуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.
3. Зураг төсвийн ажлыг гүйцэтгэх урьдчилгаа төлбөрт шаардагдах хөрөнгийг 2017 онд батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэж, нэмэлт хөрөнгийг 2017 оны төсвийн тодотгол болон 2018 оны төсөвт тус тус тусган санхүүжүүлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нар болон Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Чойжилсүрэнд тус тус даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын үүрэг гүйцэтгэгч Ж.Мөнхбат, Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайдын  
үүрэг гүйцэтгэгч

Ж.ЭРДЭНЭБАТ

Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Засгийн газрын 250 дугаар  
тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ, ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛИЙН ЭХ  
ҮҮСВЭРЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ЗУРАГ ТӨСВИЙН АЖЛЫН ТОО

Д/д	Төсвийн өрөнхийлөн захирагч				
		Нийт төслийн тоо	Зураг төсөвтэй төслийн тоо	Зураг төсөв шаардлагатай төслийн тоо	Үүнээс: Холболтын зураг төсвийн зардал шаардлагатай төслийн тоо
1	Сангийн сайд	54	-	54	-
2	Байгаль орчин аялал жуулчлалын сайд	11	1	10	10
3	Барилга, хот байгуулалтын сайд	47		47	
4	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	284	167	117	117
5	Зам, тээврийн хөгжлийн сайд	29	12	17	-
6	Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газар	39	8	31	11
7	Хөдөлмөр, нийгмийн хамгаалалтын сайд	17	1	16	-
8	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	15	11	4	-
9	Эрүүл мэндийн сайд	47		47	47
10	Эрчим хүчний сайд	14	1	13	-
	НИЙТ	557	201	356	185